

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр - “Тэрэлж байгалийн эрдэст ус савлах” үйлдвэрийн өргөтгөлийн төсөл


Төслийн зорилго: Үйлдвэрийн барилгыг 864м² -аар өргөтгөн, тоног төхөөрөмжийг шилжүүлэх, баллонтой ус үйлдвэрлэх шугамын хүчин чадлыг нэмэгдүүлэн шинээр суурилуулах, жижиг савлагаатай усыг пакетлах болон баллонтой усыг уутлах машин шинээр худалдан авах, шинэ тоног төхөөрөмжийг хангахуйц нөөцийн сав худалдан авах, ингэснээр хэрэглэгчдийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг эрүүл ахуйн шаардлага хангасан, хүний биед 100% шингэхүйц чанартай, байгалийн эрдэст усаар хангах, бүтээгдэхүүний онцлогийг таниулах замаар зах зээлд нэвтрэх, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, компаний үйл ажиллагааны хүрээг тэлэн үнэ цэнийг нэмэгдүүлэх нь энэхүү төслийн эрхэм зорилго болно.

Төсөл хэрэгжүүлэгч - Хувийн хөрөнгө оруулалттай “БЛҮГОЛД” ХХК, Улсын бүртгэлийн дугаар: 9011008143, Регистрийн дугаар:5032709, Газар эзэмших гэрчилгээний дугаар 000300571

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг - Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16-р хороо, Амарсанаа, Орхоны-1, Утас: 361560, Факс: 305056, Захирал: Б.Ариунболд

1.2 Төслийн байршил

ТЭРЭЛЖ байгалийн эрдэст ус савлах үйлдвэр нь Улаанбаатар хотоос 45 км-ийн зайд орших Налайх дүүргийн нутаг дэвсгэр болох Хөх давааны энгэрт, Горхи-Тэрэлжийн хөвөөнд гүний усны баялаг нөөц агуулсан, цэвэр агаартай, хөрсний бохирдолгүй, байгалийн үзэсгэлэнт газар 20000м² талбайд байрладаг.



Зураг 1. Төслийн талбайн байршлын зураг

УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Шинэ зураг



Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн орчны зураг – Хиймэл дагуулаас

УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 3. Төсөл хэрэгжих талбайн гадна орчны байдал

1.3 Төслийн хүчин чадал

1.3.1 Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

Манай компани нь 2005 онд цэвэр усны үйлдвэрлэл, худалдаа, борлуулалтын чиглэлээр үүсгэн байгуулагдсан. Тэрэлж байгалийн эрдэст усыг савлан үйлдвэрээс гаргадаг. Тэрэлж байгалийн эрдэст ус нь 28 сая жилийн өмнө түрэгдэн гарч ирсэн боржин чулуулагийн баялагтай Хан Хэнтийн нурууны Горхи Тэрэлжийн сав газар болох Хатан туулын хөвөөнөөс 110 метрийн гүнээс гарган авдаг байгалийн эрдэст ус юм. Манай бүтээгдэхүүн нь эрдсийн найрлагыг нь шүүж хөндөөгүй, физик химийн үзүүлэлт нь дэлхийн ундны усны стандартын гол шалгууруудыг хангасан, нэн зохимжот агууламжтай учир хүний биед 100% шингэдэг.


Тэрэлж байгалийн эрдэст ус савлах үйлдвэрийн хүчин чадал одоогоор хоногт 60,280 литр усыг боловсруулах хүчин чадалтай. Бид ажиллаж буй хугацаандаа өөрийн гэсэн үйлчлүүлэгч, хэрэглэгчидтэй болсон төдийгүй олны танил брэнд бүтээгдэхүүнээр шалгараад байна. Зах зээлд эзлэх байр суурь, хэрэглэгчийн хэрэглээний онцлог өөрчлөгдөн, өсөн нэмэгдэхийн хирээр үйлдвэрлэлийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага үүсч байгаа учир үйлдвэрийн барилгыг өргөтгөн, баллонтой усны тоног төхөөрөмжийн иж бүрэн нэг шугам худалдан авах, мөн пакетлах, уутлах автомат машин худалдан авч, үйлдвэрлэлийн хүчин чадал, агуулахын зай талбайг нэмэгдүүлэх, борлуулалт түгээлтийн сувгийг оновчтой зохион байгуулах зорилгоор энэхүү төслийг боловсруулж байна. Манайх тоног төхөөрөмжөө шинэчлэн ажиллавал өдөрт 203,920 литр жилд 51,183,920 литр усыг үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэх усны хэмжээгээ 3.38 дахин өсгөх юм.



УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 4. Шинэ үйлвэрийн харагдах байдал /урдаас /



Зураг 5. Шинэ үйлдвэрийн харагдах байдал /зүүн талаас/

1.3.2 Төслийн хүчин чадал

Тэрэлж байгалийн эрдэст ус савлах үйлдвэрийн баллонтой усны тоног төхөөрөмжийн хүчин чадал одоогоор цагт 250ш буюу 4725 литр усыг боловсруулах хүчин чадалтай. Баллонтой усны борлуулалт 2016-2018 онд дунджаар 39%-ийн өсөлттэй ажиллаж, 18.9л усны үйлдвэрийн шугамын ашиглалт 2019 онд 79%-д хүрээд байна. Мөн 2018 оны 12 сард хийгдсэн зах зээлийн судалгаанаас үзэхэд баллонтой усны зах зээлийн 5.8%-ийг нийлүүлж ажиллаж байна гэсэн албан бус тоо баримт байгаа нь бидний үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх бүрэн боломж байна гэдгийг харуулж байна.

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**


Үүний тод жишээ нь 2016.11-р сард сарын борлуулалт 20,000 ширхэг , 2017.10 сард 30,000 ширхэг, 2018.10-р сард 40,000 ширхэг ус борлуулснаас харж болох юм. Иймд энэ өсөлтийг хадгалах, үүнээс илүү борлуулалтыг хийж гүйцэтгэхэд үйлдвэрлэлийн хүчин чадлыг сайжруулах шаардлага тулгараад байна.

Хүснэгт 1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хүчин чадал

Бүтээгдэхүүн	Цагт үйлдвэрлэх тоо	Хоногт үйлдвэрлэх литр	Сард үйлдвэрлэх литр	Жилд үйлдвэрлэх литр
0.5 литр	2,000	12,480	274,560	3,132,480
1.5 литр				
0.33 литр				
0.780 литр				
5 литр	250	10,000	220,000	2,510,000
18.9 литр	1,200	181,440	3,991,680	45,541,440
Нийт хүчин чадал		203,920	4,486,240	51,183,920

ТЭРЭЛЖ байгалийн эрдэст ус савлах үйлдвэр нь жилд нэг ээлжээр 15 сая литр ус савлах хүчин чадалтай, ариутгалын аппарат, бактергүйжүүлэлтийн шат дамжлага бүхий 6 төрлийн савлагааны шугамтай, бүрэн автомат тоног төхөөрөмжтэй. Үйлдвэрийнхээ дэргэд чанарын шинжилгээ, судалгааны итгэмжлэгдсэн лабораторийг байгуулж, өдөр бүр усныхаа чанарт хяналт тавин ажилладаг. Үйлдвэрийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ гарган чацаргана, мойл, улиас тарьж зүлэгжүүлсэн бөгөөд гүүр, засмал зам, усан оргилуураас бүрдэх үйлдвэрийн эко, эрүүл орчныг бүрдүүлсэн.

Зураг 6. Үйдвэрийн технологийн схем



УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УСАНД ХҮНИЙ БИЕД
ХАМГИЙН ИХ ХЭРЭГТЭЙ ЭРДЭС БОДИСУУД БАГТСАН

МАГНИ СУЛЬФАТ

ХЛОР ГИДРОКАРБОНАТ ФТОР

- ХОРТ ХАВДАР
- ЧИХРИЙН ШИЖИН
- ТОГТВОРГУЙ ДАРАЛТ
- АРЬСНЫ ҮРЭВСЭЛ ЗЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ ЖИРЭМСЭН БОЛОН ХӨХҮҮЛ ЭЭЖ БАГА НАСНЫ ХҮҮХДҮҮД БИЕ БЯЛДАР БОЛОН ОЮУНЫ ХҮЧ ЗАРЦУУЛДАГ ХҮМҮҮСТ МАШ ЧУХАЛ, АМИНДЭМ ЭРДЭСТЭЙ УС

Зураг 7. Эцсийн бүтээгдэхүүний чанар



Зураг 8. Үйлдвэрийн гаднах тохижилт



Зураг 9. Ажилчидын байр

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 10. Усан ориглуур болон хүлэмж

Нийт 30978 м² талбайгаас 24520 м² талбай нь ногоон байгууламжтай Тамхи татах цэг, амралтын саравч, явган хүний замтай. Эзэмшил газрын ногоон байгууламжийн урд хэсгээр шигүү бусад хэсгээрээ тархсан байдалтай, байгалийн тогтоцоороо ургасан бут, сөөг, бургас, хар модтой. Үндсэн орцны хэсгээс үйлвэр хүртэл шинээр бут сөөг тарисаншинээр нэмж мод тарих шаардлагагүй.

Үйлдвэрийн бүсэд өдөрт дунджаар цэвэр ус түгээлтийн 5-6 дунд оврийн ачааны машин оржгардаг бөгөөд онцгой шаардлагатай үед хогны машин, галын машин, нүүлгэлтийн машин явахыг зөвшөөрдөг. Эзэмшил газар болох хашаан дотроо 5 машины зогсоолтой харин хашааны үүдэнд 20-25 машины зогсоолтой.



Зураг 11. Төсөл хэрэгжиж буй талбайн харагдах байдал / дээрээс /


УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг 12. ТЭРЭЛЖ байгалийн эрдэст ус савлах үйлдвэрийн дотоод орчин

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

- 1-р хэсгийн танк нь 300 литр усны багтаамжтай, нэг удаад 40 баллон угаана.
- 2-р хэсгийн танк нь 450 литр усны багтаамжтай, босоо 3 сойз, баллоны хүзүү угаах 3 сойзтой
- 3-р хэсгийн танк нь 300 литр усны багтаамжтай, нэг удаад 40 баллон угаана.



3. Дотор угаалгын машин

Дотор угаалгын машин нь 19 хэсэг 6 танктай. Энэхүү машин нь цагт 1200 баллон угаах хүчин чадалтай. Нэг удаад хамгийн ихдээ 95 баллон угаана.

- Угаалгын өмнөх хэсэг – 500 литр усны багтаамжтай танктай, 2 угаах дамжлага, 1 уурааруулах дамжлагатай
- Бодистой угаалгын хэсэг - 1500 литр усны багтаамжтай танктай, 8 угаах дамжлага, 1 уурааруулах дамжлагатай
- Зайлах хэсэг – 450 литр усны багтаамжтай танктай, 2 угаах дамжлага, 1 уураар утахдамжлагатай
- Халдваргүйжүүлэх хэсэг – 900 литр усны багтаамжтай танктай, 5 төрлийн насосоор дотортал, 2 төрлийн насосоор 45⁰С температураар угаана.
- Хоёр дахь зайлах хэсэг – гадна болон дотор хэсгийг 2 удаагийн дамжлагаар 200 литр усаарзайлна.
- Сүүлийн зайлах хэсэг – 450 литрийн багтаамжтай танктай, 1 угаах дамжлага, 1 уураар утахдамжлагатай.



4. Дүүргэх төхөөрөмж



5. Бөглөх машин



Бөглөх систем нь дараахь зүйлсээс бүрдэнэ: Cap hooper, Cap elevator, Cap sorter, Canal chute, Neckline cap

Cap Hooper: Hooper нь AISI 304L Stainless Steel-ээр хийгдсэн. Энэ нь 2400 бөглөөний багтаамжтай бөгөөд нэг дүүргэлтээр 2 цаг ажиллана.

Бөглөө байрлах хоолой налуу учир хүний гар оролцохгүйгээр ажиллах боломжтой.

6. Баллонтой ус автомат уутлах машин

Одоогийн нөхцөлд баллонтой усыг уутлан савладаг оператор ажиллаж байгаа бөгөөд одоогийн машин хүчин чадал цагт 250 ширхэг ус үйлдвэрлэж байна. Бид дээрх тоног төхөөрөмжийг худалдан авсанаар цагт 1200 ширхэг ус үйлдвэрлэх бөгөөд энэ тохиолдолд хүн гараар уутлах боломжгүй болох учир автомат машин худалдан авах хэрэгцээ үүсч байгаа юм.



7. Нөөцийн сав – Water storage tank

Үйлдвэрлэлийн хүчин чадлыг гүйцэж нөөцлөх хэрэгцээг хангах нөөцийн савыг нэмж авна. Баллонтой усны шугамын хүчин чадлыг 4 дахин нэмэгдүүлснээр усны нөөцийн савны хүрэлцээ байхгүй болох тул одоо ашиглаж буй 5 тоннын нөөцийн савыг 20 тонн болгон нэмэгдүүлэх юм.

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



8. Жижиг савлагаатай усны шошго наах болон Пакетлах машин

Жижиг савлагаатай усны шошгоны машин шинээр худалдан авсан. Одоогийн ажиллаж байгаа машин 2017 онд ашиглалтанд орсон хэдий ч ажиллагаа хэвийн боловч, гар тохиргоо байнга хийх шаардлагатай болдог бөгөөд үүнээс үүдэлтэй шошго таслах, шошго агшаах зэрэгт алдаа их гардаг. Энэ нь бүтээгдэхүүний гологдол их гаргаж байна. Иймд гар тохиргоо хийгдэхгүй, автомат ажиллагаатай алдаа гарахгүй, шошгоны өнгө үзэмж, чанар сайжирна. Мөн гологдол бага гарна.



Жижиг савлагаатай ус пакетлах бүрэн автомат машин худалдан авах. Одоогийн ажиллаж байгаа машинууд 2011 онд ашиглалтанд орсон учир элэгдэлд орж, гар ажиллагаа ихтэй, үлээх, савлах машины хурдыг гүйцэхгүй байгаа учир шинэчлэн бүрэн автомат машин авах шаардлагатай байна.



Тоног төхөөрөмжийн жагсаалт

Тоног төхөөрөмжийн		
1	Баллонтой усны цагт 1200 ширхэг үйлдвэрлэх хүчин чадалтай иж бүрэн шугам	Турк улс
2	Нөөцийн сав авах	Турк улс
3	0.33-1.5 пакетлах машин	Турк улс
4	5л пакетлах машин	Турк улс
5	Жижиг савлагаатай усны шошгоны машин	Турк улс
6	Баллонтой ус уутлах автоматмашин	Турк улс

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ажиллах хүчин - Одоо ажиллаж буй захиргаа, борлуулалт, үйлдвэр гэсэн нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулах бөгөөд төслийн үр дүнд 70 орон тоо нэмэгдэж нийт 110 ажилтантай болох юм.

Үүнээс 2019 оны байдлаар үйлдвэрт 24 хүн ажиллаж байна. Хэрэгцээ шаардлагаас үүдэн 2023 он гэхэд 37 ажиллагсадтай болохоор төлөвлөсөн. Нэмж угсарч буй тоног төхөөрөмжийг ажиллуулах, машины операторууд, мөн үйлдвэрийн өргөтгөлтэй холбоотойгоор борлуулалтын бүсийг 32 болгож, сүлжээ дэлгүүр, жижиг дэлгүүрийн түгээгчийг 10 болгож, жижиг усны борлуулалтын бүсийг 4 болгож, жижиг ус, 5 литрийн шугамыг зэрэг ажиллуулахад шаардагдах шугамын оператор 5, татан авалтын машины жолоочийг 10 болгож, борлуулалтын менежер, захиалгын менежерийг тус тус 2 болгож, нярав, тоцооны нягтлан ачигчийг тус бүр 2-оор нэмэгдүүлэхээр төлөвлөлөө.

Хүснэгт 2. Ажиллах хүчний тоо

	№	Албан тушаал	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	
Үйлдвэр	1	Үйлдвэрийн дарга	1	1	1	1	1	
	2	Технологич	1	1	1	1	1	
	3	Техникч	1	1	1	1	2	
	4	Үйлдвэрийн нярав	1	1	1	1	1	
	5	Шугамын чанар шалгагч/ 18.9л	2	3	3	3	3	
	7	Сав үлээх машины оператор	1	1	1	1	1	
	8	Савлах машины оператор 18.9л	2	2	2	2	2	
	10	Савлах машины оператор /0.33-1.5л/	1	2	2	2	2	
	11	Туслах угаагч ажилтан/баллон угаагч/	1	1	1	1	1	
	12	Туслах угаагч ажилтан/баллон шалгагч/	1	1	1	1	1	
	13	Туслах угаагч ажилтан/уутлагч/	1	2	2	0	0	
	14	Туслах угаагч ажилтан/ачих/	1	2	2	2	4	
	15	Туслах угаагч ажилтан/бэлдэц углах/	1	2	2	2	2	
	16	Туслах угаагч ажилтан/шошго оператор/	1	2	2	2	1	
	17	Харуул	1	1	1	1	2	
	18	Тогооч	1	1	1	1	1	
	19	Жолооч татан авалт /баллон	2	4	6	7	2	
	21	Жолооч татан авалт /жижиг ус	1	1	1	1	2	
	22	Зөвлөх доктор гэрээт	1					
	23	Зөвлөх лаборонт гэрээт	1	1	1	1	1	
	24	Зөвлөх техникч гэрээт	1					
			Дүн	24	32	34	35	37

1.4 Төслийн дэд бүтэц

Усан хангамж – Төсөл хэрэгжүүлэх талбайд гүний худагтай. Түүнийгээ унд ахуйн хэрэгцээндээ ашиглана. Гүний худгийн гүн 110 м

- Усны тогтсон түвшин /статик/ 6 м
- Цооногийн ашиглалтын усны ундрага 3,3 л/с,
- Солбицол: Х 47° 49' 26.90" Y 107° 19' 54.71"

Цэвэр ус үйлдвэрлэх үйлдвэрийн усны хэрэгцээ

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тус үйлдвэр нь хоногт **203,920л** ус үйлдвэрлэх ба 1000л ус үйлдвэрлэхэд 10 м³ ус шаардлагатай. Энэ нь хоногт **19,456тн/хоног** х 10 м³/тн = 194,56 м³/хоног, жилд 251 хоног ажиллана гэвэл нийт 48,834.56 м³/жил ус хэрэглэх тооцоо гарч байна. ¹(* - *БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 3 дугаар хавсралт/*

Иймд тус үйлдвэрийн усны хэрэгцээг өөрийн гүний худаг бүрэн хангаж байна.

Унд ахуйн ус хэрэглээний тооцоо

Тус үйлдвэрт 32 ажиллагсад байнга ажиллах ба нэг ажилчны хоногийн усны хэрэгцээг 20* л гэж үзвэл 640 л ус хоногт, жилд /251хоног/ 160,6 м³/жил 0,64м³/хоногт хэрэгцээтэй байна.

²(* - *БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалын 12 дугаар хавсралт*

Зүлэг талбай услах мод услахад хэрэгцээтэй усны хэмжээ нь 116м² х 4л/м² =0,46м³/хоног 69,0м³/жилд ус шаардлагатай байна

Цахилгаан – Төсөл хэрэгжих орчимд дэд бүтэц шийдэгдсэн газар учир хамгийн ойр байрлах хүчдэлээс шугам татаж цахилгаанаа шийдсэн. Бага оврын цахилгаан үүсгүүртэй.

Дулаан хангамж – Төслийн үед нам даралтын зуухаар нүүрс түлэн дулаанаа хангадаг.



Зураг 16. Цахилгаан үүсгүүр болон цахилгаан зуух

Харилцаа холбоо – Улаанбаатар хотын ойролцоо байрлах тул харилцаа холбооны иж бүрэн тоноглолтой.

1.5 Төслийн хог хаягдал

1.5.1 Төслийн ахуйн хэрэглээнээс үүсэх хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас дараах хатуу хог хаягдал гарна. Үүнд: Энгийн хог хаягдал – Энгийн хог хаягдлын дийлэнх хувийг ахуйн хог хаягдал бүрдүүлнэ. Ажилчдын өдөр тутмын хэрэглээнээс гарах ахуйн гаралтай хог хаягдлууд болох хоол хүнсний үлдэгдэл, материалын сав баглаа боодол цаас, пластмасс, төмөр, шил, яс, мод зэрэг хог хаягдлууд гарна.

Хог хаягдлыг зайлуулах арга хэмжээ

¹ “Хүнсний үйлдвэрийн усны норм”, архи пиво, ундаа /савласан усны үйлдвэр – 10 м³)

² Худаг, булаг зэрэг уснаас зөөврөөр хангадаг гэр хороолол – 20л/хоног/хүн)

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Энгийн хог хаягдал - Төсөл хэрэгжүүлэгчид энгийн хог хаягдлыг дараах байдлаар зайлуулах, мөрдөж ажиллах зөвлөмжийг санал болгож байна.

1) “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам” -ын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах шаардлагатай.

2) Дараах шаардлагыг хангасан хогийн савтай болох шаардлагатай.

Үүнд: Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн;

Галд тэсвэртэй материалаар хийгдсэн;

Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэнбайх

3) Налайх тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ- тэй хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн,аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулж зайлуулдаг.

1.5.2 Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдалын тооцоо

Хатуу хог хаягдал - 2019 онд Тэрэлж байгалийн эрдэст усны үйлдвэрт 24 хүн ажиллаж хил ирэх тусам нэмэгдэн 2023 онд 37 хүн ажиллахаар төлөвлөсөн. Хог хаягдалыг тооцоог ажиллах хүчний 5 жилийн дунджаар тооцон 32 хүнээр тооцов.

Нийт 32 хүн * 0,3 кг=9.6 кг 30 хоног буюу сард 288 кг, жилд ажиллах хугацаа нь 12 сар буюу 365 хоногоор тооцож үзвэл 3.456 тн орчим хатуу хог хаягдал гаргахаар байна.

/Нам даралтын зуухнаас үнс гарах бөгөөд сард 2 удаа тээвэрлэнэ. / Тус үйлдвэрт доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гаргахаар байна.Үүнд:


- Хүнсний зүйлийн сав, баглаа, боодол
- Бие засах газрын хаягдал
- Полиэтилен уут,баглаа,боодол
- Үнс
- Хоолны үлдэгдэл
- Бусад

Тус компани нь төслийг хэрэгжүүлэх явцдаа хатуу хог хаягдлыг зайлуулах асуудлыг “Хог хаягдлынтухай” улсын хуульд заасны дагуу холбогдох байгууллагатай “Хог хаягдал тээвэрлэн зайлуулах” гэрээ байгуулсны үндсэн дээр шийдвэрлэж байна. Төсөл хэрэгжүүлэгч нь хатуу хог хаягдлын цэгийг баазынхаа зүүн урд талд ангилан ялгаж хийх тусгай цэг байгуулж ангилан ялгаж битүү саванд хийн гэрээний дагуу тогтсон цэгт зайлуулж байна.

Шингэн хог хаягдал – Хаягдал бохир усыг орчин үеийн байгальд хор хөнөөл багатай байхаар бага оврийн өөрийн цэвэрлэх байгууламжтай байхаар шийдвэрлэж цэвэршүүлсэн усаар ногоон тохижолт бүхий хийгдэх мод зүлгийг услах боломжтой байхаар хийнэ. Тус үйлдвэр нь “Атмор” ХХК-ны цэвэрлэх байгууламж ашиглана.

Биорок нь бохир усыг цэвэршүүлэх хамгийн найдвартай, үр дүнтэй шийдлийг санал болгож байна. Энэ систем цэвэршүүлэх системдээ цахилгаанаар ажилладаг агаар үлээгч эсвэл агаарын дифузер ашигладаггүй. Иймд цахилгаан ашигладаггүй тул хамгийн бага ашиглалт, арчилгааны зардалтай. Уг технологийн давуу талууд нь хэрэглэгчдэд уламжлалт цэвэрлэх байгууламжуудтай харьцуулахад их хэмжээний зардал хэмнэхээс гадна арчилгаа хийх шаардлагагүй тул нэмэлтсэлбэгний зардал гарахгүй. Цэвэршүүлээд гарсан цэвэр усны түвшин нь хуучин болон уламжлалт бохир ус цэвэршүүлэх аргачилалуудаас хэд дахин үр дүнтэй. Үйлдвэрийн ажилчдын шингэн хаягдлын тооцоо нь хоногт 0,4м³ байхаар тооцоо гарсан.

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 17. Үйлвэрийн ус цэвэрлэх байгууламжын ерөнхий схем

Технологийн байгуулалт

Бохирын системийн бохир хүлээн авах оруулга нь газрын түвшингөөс 7м гүнд байрлахаар хийгдсэн тул шугам хоолойн уртаас хамаарч 1м хоолойд 0,7см хэвгий унаж байхаар тооцон объектын бохир усны гаргалгааны түвшинг тодорхойлно. Цэвэрлэх байгууламж хүртэлх шугамын диаметр нь $\Phi=100$ PVC 0 хуванцар шар хоолой байх бөгөөд халдаг кабелиар 20см алслалттай ороон резинэн хар дулаалгаар дулаална

Бохир ус цэвэрлэх байгууламжаар дамжин 3 үе шаттай цэвэрлэгдсэний дараа шингээх худаг луу шилжих бөгөөд уг худаг нь газрын түвшингээс 1 м гүнд байрлана. Цэвэрлэгдсэн ус шингээх талбай луу шугам хоолойн уртаас хамаарч 1 м хоолойд 0,7 см хэвгийгээр унах бөгөөд хуванцар хоолой $\Phi=50$ PVC-г халдаг кабелиар 20см алслалттай ороон резинэн хар дулаалгаар дулаална.

Дагуугийн зүсэлт

Бохир усны хэмжээ 1 м³/хоногос ихгүй үед элс, элсэрхэг хөрсөнд шүүрүүлэх худагхийнэ. Худгийн суурь хөрсний усны түвшингээс дээш 1м-ээс багагүй зайтай байна.

1. Шүүрүүлэх худаг нь $\Phi=319$ диаметртэй даацийн хуванцар нүхтэй кольцо байна. Усыг шүүрүүлэн гаргах нүх нь худгийн хананд байна.
2. Шүүрүүлэх талбай нь 2x2 м-ээс ихгүй, гүн нь 2,5 м-ээс багагүй байна. Шүүрүүлэх гадаргын 1 м² талбайн ачаалал элсэн хөрсөнд 80л/хоног, элсэнцэр хөрсөнд 40 л/хоног байна.
3. Ёроолын шүүрүүлэх материалыг хөрснөөс шалтгаалан -2,5 м-ээс дээш 1 м хүртэлх зузаантай хайрга дэвсэж дээд түвшингүүдэд сайрга, бүхэлжсэн үнс болон бусад материал оролцуулана

Бохирын СЕПТИК системийг ашиглах зөвлөмж мөрдөх зарчимууд

- Засварын ажил хийхдээ мэргэжлийн хүмүүсийг ажиллуулах
- Тунгаагч сав, түгээх төхөөрөмжийг цэвэрлэх болон нэвтрэх нүхний таглаа өргөгчийг суурилуулж, тухайн таглаа нь байнга цоожтой байх эсвэл хүүхэд онгойлгохоос сэргийлж, хангалттай хүнд жинтэй байлгах
- Бохирын системээ жил бүр шалган үзэж, тунгаагч савыг 2-3 жил тутамд мэргэжлийнхүмүүсээр цэвэрлүүлэх хэрэгтэй

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

- Хяналт болон бусад засвар үйлчилгээнүүдийн тухай тэмдэглэл байнга хөтлөх
- Системийг хэт ачаалалд оруулахаас сэргийл. Ус байнга алддаг цорго, жорлонгийн бочкигзасаж, усанд орох, угаалгын машин болон аяга таваг угаагчийг хэрэглэхдээ ус хэт ихээр үр ашиггүй зарцуулахаас зайлсхийж, усны цорго болон шүршүүрийн толгойн хэсэгтфорсунк суулгах болон жорлонд ус хэмнэх аргуудыг хэрэглэх
- Усны бусад эх үүсвэрүүд жишээлбэл дээврийн болон бороо, үерийн усыг бохирын систем руу орохоос сэргийлж, чиглэлийг нь өөрчлөх суваг, шуудуу хийх хэрэгтэй. Чиглэлийг өөрчлөхөд хана босгох, хавтгай гадаргуутай чиглэл өөрчлөгч зэргийг ашигла
- Гэр ахуйн бус аюултай химийн хаягдлыг бохирын системдээ хийхийг хориглох.

Хориглох зүйлс

- Шалтгаангүйгээр тунгаагч савруу бүү нэвтэр. Тунгаагч саванд хуримтлагдсан зарим хийнүүд нь амьсгал боогдуулж болно
- Бохирын системийн дээр машинаа тавих эсвэл машинаар явахыг хориглоно.
- Шингээгч худаг байрладаг талбайг асфальт эсвэл бетоноор бүрхэж болохгүй. Зүлэг тарих нь хамгийн зөв бөгөөд зөвхөн элэгдлээс хамгаалаад зогсохгүй илүүдэл усыг ч гадагшлуулдаг
- Бохирын хоолойруу техникийн тос тосолгооны материал, шатахуун, химийн бодис, будаг, фото зургийн шингэн, пестицид зэргийг хийхийг хориглоно. Тэдгээр нь тунгаагч саван дахь бактерийн үйл явцыг хямралд оруулж улмаар хөрсний усыг бохирдуулдаг
- Жорлонгоо хогийн сав мэтээр хэрэглэхийг хориглоно. Жорлонд кофены нунтаг, яс, тамхины иш, эмэгтэйчүүдийн ариун цэврийн хэрэгсэл, цаас, салфетка зэрэг амархан бөглөрөл үүсэгдэг бусад материалуудыг хийхийг хориглоно.
- Хэрвээ ТС-д хог хаягдал ихээр хийвэл цэвэрлэх давтамж 50%- иар ихсэх магадлалтай гэдгийг анхаарвал зохино
- Тунгаагч сав руу энзим болон түүхий дрож зэрэг бактерийн үйл явцыг хэт ихэсгэдэг бодис оруулж болохгүй. Энэ нь хөрсний бүтцэд нөлөөлж ургамал ургахад сөргөөр нөлөөлж хөрсний усыг бохирдуулна.

1.5.3 Төслөөс үүсэх хог хаягдлыг зайлуулалт

Хатуу хог хаягдлыг холбогдох байгууллагтай гэрээ байгуулж зайлуулахаар төлөвлөсөн байна. Мөн түүхий эд материалын сав баглаа боодолыг ихэнх нь шуудай, хайрцаг зэрэг ихэнх нь байдаг ба дүүргийн ТҮК гэрээ байгуулан зайлуулдаг.

1.5.4 Төслөөс үүсэх хог хаягдлыг зайлуулах зөвлөмж

Хаягдлыг багасгах болон боловсруулалтын үр ашиг

Хаягдлыг багасгах нь байгаль орчны менежментийн чухал зорилтуудын нэг. Хүнсний үйлдвэрт хаягдлыг дараах замаар үр дүнтэй багасгаж болно. Үүнд:

Усны хэмнэлт;

Эрчим хүчний хэмнэлт;

Хаягдал усны урсгалыг тусгаарлах зэрэг орно.

Таагүй, хүчтэй үнэр, хатуу болон шингэн хаягдлыг багасгахад дараах боловсруулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

Тоног төхөөрөмжийг угааж цэвэрлэхэд ариутгагч бодис, усыг оновчтой ашиглах;

Усны хэрэглээг дараах аргаар бууруулах:

Тоног төхөөрөмжийг угааж цэвэрлэхэд өндөр даралттай, хэмжээ багатай хоолойг ашиглах;Автоматаар хаагдах крант хэрэглэх;

Хатуу хаягдал болон шингэн хаягдлын концентратыг бохир усны ерөнхий урсгалд оруулахаас сэргийлэх;

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг БОАЖ сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын болон газрын доорх усны нөөц хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэмэдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр орно.

Аймаг нийслэлийн байгаль орчны газар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авсан талаарх мэдээллийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд оруулж, хүлээн авсан тухайгаа төсөл хэрэгжүүлэгчийн бүртгүүлсэн цахим шууданд ажлын 5 хоногт багтаан хариумэдэгдэнэ.

Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр: Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний байгаль орчны болон ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрт нь тодруулга хийж шинэчлэн тооцно.

БОМТ -ний хэрэгжилтийн талаарх тухайн жилийн хяналт, үзлэгээр төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр, түүний ойр орчмын нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд дүгнэлт хийх ажлыг байгаль орчны хяналт шинжилгээний ажлын үр дүнгүүдэд үндэслэн хийх, БОМТ -ний биелэлтийг дүгнэхдээ жилийн хяналт, үзлэгээр төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын холбогдох хяналтын байцаагч нар, ард иргэдээс тавих шаардлага, хүсэлтийг хэрхэн хангасныг мөнөвч үзэх ёстой.

БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 10 сарын 1-ний дотор БОАЖЯ-нд ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Нэгдсэн дүн

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	Тухайн жилийн зардал
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	13 651,0
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/	240,0
3.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6.	Осол, Химийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	700,0
7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	600,0
8.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1068,0
	Нийт	16 259,0

УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1.АГААР ОРЧИН					
Хөргүүрт ашиглах хөргөлтийн бодис	Орчны болон ажлын байрын агаарын бохирдлын байдалд жилд 1 удаа шинжилгээ хийлгэх	Үйлдвэр, агуулахын хүрээнд	--*--	Төслийн бүх үе шатанд	
Халаалтанд нүүрсний утаа, техникийн утаа ашиглах машин	Үйлдвэрийн байрыг механик агааржуулалтын иж бүрэн татах системтэй болгох	Агуулахад	800.0	2024 онд	
ДУУ ЧИМЭЭ					
Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ.	Машин тоног төхөөрөмжийг дуу шуугиан хамгийн бага тарах нөхцөлтэйгээр байршуулан ашиглах	Агуулах, төвийн байранд	--*--	2024 онд	MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ
	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Ажиллагсад	876,0		MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
	Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийх,	Агуулах, төвийн байранд, хашаанд	ОХШХ тусгасан		3 цэгт жилд 3 удаа
2. УСНЫ НӨӨЦ, ЧАНАР					
Төслийн явцад усыг их хэмжээгээр, замбараагүй хэрэглэсэн тохиолдолд усны нөөцөд шууд нөлөөлөх магадлахтай	Усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, Тоолуурын заалтын дагуу ус ашигласаны төлбөрийг төлөх	Төслийн хүрээнд	--*--	2024 онд	- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, - Усны тухай хууль
Бохир усыг көвшөөрөгдөх хэмжээнд нь хүртэл цэвэрлэж хүрээлэн буй орчинд нийлүүлж байх	Бохир усыг цэвэрлэж саармагжуулж байх бохир усны оролт гаралт голд нийлүүлэхэд хяналт тавьж байх	Төслийн Хүрээнд	Бохир усны худагт	2024 онд	Ус бохирдуулсны нөхөн төлбөрБОАЖС 2019оны 11-01 А/635 журам
3.ХӨРС, УРГАМЛАН БҮРХЭВЧ					
Барилга байгууламжийн улмаас ургамалан нөмрөгт нөлөөлсөн байдал	Хатуу хог хаягдлыг хадгалах зориулалтын битүүмжилсэн хогийн савтай болох, хог хаягдлын цэгийг хатуу хучилттай болгох	Агуулах, төвийн нхүрээнд	1500.0	2024 онд	MNS 3307:1991, MNS3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2019 Хөрс

УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн улмаас талбайн гаднах талбайд шатах тослох материал алдагдах, тоосжилт үүсэх	Агуулах, үйлдвэрийн гадна талбайд цэвэрлэгээ, арчилгааг тогтмол хийж байх	Агуулах, төвийн хүрээнд	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжих хугацаанд	Бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хатуу хог хаягдлыг тодорхой хугацаанд хог хаягдлын нэгдсэн цэгт зайлуулж байх	Төслийн хүрээнд	--*--	Сар бүр	
4. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах, мөрдөх талаар сургалт явуулах	Үйлдвэрийн бүх ажилчдад	3175,0	Жил бүр	Компаний дотоод журмаар Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль Орчны Аудит хийх аргачлал, эрх олгох журам /А-126/ Газрын тухай хууль	
Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах,	Төслийн хүрээнд	4800,0	Жил бүр		
Байгаль орчны хөндлөнгийн аудит хийлгэх		2 500,0	2024он		
Газрын чанарын хянан баталгаа хийлгэх		Дотоод төлөвлөлтөөр	5 жилд 1 удаа		
Нийт дүн		13651,0			

УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Ногоон байгууламж бий болгох, нөхөн сэргээх төлөвлөгөөнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Төслийн хашаанд тарьсан зүлэг, бут сөөгийг арчлах	Төслийн талбайд	100,0	Жилд 2 удаа	Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага” /MNS 5918-2008
	Төслийн хашаанд тарьсан чацарганы модыг арчлах	Төслийн талбайд	100,0		
	Олон төрлийн мод тарих, усалгааны систем хийх	Төслийн талбайд	40.0		
	Нийт дүн:		240,0		

1.3 Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах аргахэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /мян.төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, саатал, техник технологийн болон шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Барилга байгууламж техник тоног төхөөрөмжид	ҮАзардалд	Өдөр бүр, тогтмол байгаль орчны мэргэжилтэн хариуцна/	Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд Бүх ажилчдад	500.0	Сургалтыг улирал бүрт 1 удаа	
Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	200.0	Жил бүр	
Нийт дүн			700.0		

УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	Жил бүр	350,0	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Шингэн хаягдлыг зайлуулж буй шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж засвар үйлчилгээг хийж байх, нийлүүлж буй бохир усны найрлагад хяналт тавих	Төслийн эхэн үед болон ашиглалтын үед	250,0	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Хийн хаягдал гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах		Үйл ажиллагааны зардалд тусгах	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Нийт			600,0	

1.5 БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваар

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Сум, багийн иргэдэд	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	10-р сар	Нутгийн иргэдийн саналыг хавсаргах	-
БОАЖЯ-ны ХБОБНУГ -г	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	11-р сар	-	-

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Блүголд” ХХК-аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөлөх байдлын үнэлгээний тухай, Монгол Улсын хуулиудын дагуу “Блүголд” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Блүголд” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хянах үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээнийх байршил	Хяналтын давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1	Агаарын чанар: /Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх.	Үйлдвэрийн байранд 1 цэг, төслийн талбайд 1 цэг	Агаарын найрлага: Улиралд 1 удаа	25.0 х 4 удаа х 2 цэг=200,0	MNS 4585-2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийннорм,
2	Бохир усны хяналт шинжилгээ	Үйлдвэрийн бохир усны оролт гаралт дээр голд нийлүүлэх хэсэгт	--*--	3 цэгт х 3 дээж х 2 удаа 36,0=648,0	“Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015” MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж

**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭР ХӨХ ДАВААНЫ ЭНГЭРТ
БАЙРЛАХ “ТЭРЭЛЖ БАЙГАЛИЙН ЭРДЭСТ УС САВЛАХ ҮЙЛДВЭР” - ИЙН ТӨСЛИЙН 2024 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

					MNS 13.060.50 Усны чанарын стандарт
3	Хөрсний төлөв байдал, бохирдол:	Үйлдвэрийн хашааны гадна талбайд, хатуу хог хаягдлын талбайн ойр тус бүр 1 цэг сонгох	Жилд 2 удаа.	2 цэгт х 2 дээж х 1 удаа х 28,0 = 112,0 Хүнд металл 2 цэгт х 2 дээж х 1 удаа 27.0=108 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж-28.0₮, хүнд металлын шинжилгээ 1дээж – 27.0₮/	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга
Төслийн байгаль орчны хяналт шинжилгээний ажлын ашиглалтын эхний жилийн нийт зардлын дүн				1068,0	

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **16 259.0 мян.төгрөгийг** төлөвлөж өглөө.